

**“ОЙН САНД ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ГОЛОМТ,
ТАРХАЛТЫГ ТОГТООХ СУДАЛГАА ХИЙХ”
ОйГ/202303002 ТООТ ТЕНДЕР БАГЦ 2.**

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН



© Энэхүү тайланг ойн газрын зөвшөөрөлгүй хэвлэх, түгээх, хуулбарлахыг хориглоно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙ ГАЗАРТ

Хэнтий, Дорнод, Төв аймаг Улаанбаатар хотын ногоон бүс, БогдХан уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн ойн санд тархсан хөнөөлт шавжийн тооны нягтшлыг тогтоох судалгаа, тэмцэх арга хэмжээ явуулах талбай сонгох, тэмцлийн ажлын үр дүнг тооцох, мониторингийн судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын явцын тайланг танилцуулж байна.

ХЭНТИЙ, ДОРНОД, ТӨВ АЙМАГ, УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БҮС, БОГД ХАН
УУЛЫН ДЦГ, ГОРХИ, ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН БИОЛОГИ,
ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ТАРХАЛТ, НЯГТШЛЫГ ТОГТООХ, ТЭМЦЛИЙН АЖИЛ
ЯВУУЛАХ ТАЛБАЙГ, СОНГОХ, ТЭМЦЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОХ,
МОНИТОРИНГИЙН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН ЯВЦЫН ТАЙЛАН

НЯМЫН ӨНДӨР ХХК

АХЛАХ СУДЛААЧ:

Д.ГАНБАТ

БИОЛОГИЧ, ОЙН ШАВЖ СУДЛААЧ, БИОЛОГИЙН УХААНЫ МАГИСТР.

СУДЛААЧИД:

Б.МӨНХЦЭЦЭГ

БИОЛОГИЧ, ШАВЖ СУДЛААЧ. БИОЛОГИЙН УХААНЫ ДОКТОР

Г.БАТСАЙХАН. ОЙН АЖ АХУЙН ИНЖЕНЕР, ХААУ-НЫ ДОКТОР.

О.ЛХАГВАЖАРГАЛ. ОЙН АЖ АХУЙН ИНЖЕНЕР

Д.ЧИМЭГСАНАА. ОЙН МЭРГЭЖИЛТЭН, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

АГУУЛГА

ОРШИЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

- 1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО
- 1.2. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТ
 - ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ
 - АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ
- 1.3. СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА
- 1.4. СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГАЗАР НУТАГ, ХЭМЖЭЭ
 - Судалгаа хийгдсэн цэгүүд, байршил

ХОЁР. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- 2.1. ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ, ТАРХАЛТЫГ ТОГТООХ АЖЛЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЛЭГДСЭН БАГАЖ, МАТЕРИАЛ
- 2.2. СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН
 - АЖЛЫН ХУВААРИЛАЛТ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ШААРДЛАГАТАЙ ЧАДВАРЫН ТҮВШИН
- 2.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЖЛЫН ХЭМЖЭЭ

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

- 3.1. СУДАЛГААНЫ ХУГАЦААНД БҮРТГЭГДСЭН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН
- 3.2. ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ТАРХАЛТ, ТООНЫ НЯГТШИЛ, ТАРХАЛТЫН ЦЭГҮҮД, ТЭМЦЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ ТАЛБАЙ

ТЭМЦЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ ТАЛБАЙ СОНГОХ ХАВРЫН СУДАЛГАА

- Нийслэлийн ногоон бүс, Горхи Тэрэлжийн БЦГ, Богд Хан уулын ДЦГ-ын ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт популяцийн тооны нягтшил, тархалтын цэгүүд, судалгаа хийгдсэн газруудад тэмцлийн ажил явуулах талбайн сонголт
- Хэнтий, Дорнод, Төв аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт популяцийн тооны нягтшил, тархалтын цэгүүд, судалгаа хийгдсэн газруудад тэмцлийн ажил явуулах талбайн сонголт

ТЭМЦЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ ТАЛБАЙ СОНГОХ НАМРЫН СУДАЛГАА

- Нийслэлийн ногоон бүс, Горхи Тэрэлжийн БЦГ, Богд Хан ДЦГ-ын уулын ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт популяцийн тооны нягтшил, тархалтын цэгүүд, судалгаа хийгдсэн газруудад тэмцлийн ажил явуулах талбайн сонголт
- Хэнтий, Дорнод, Төв аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт популяцийн тооны нягтшил, тархалтын цэгүүд, судалгаа хийгдсэн газруудад тэмцлийн ажил явуулах талбайн сонголт

ДӨРӨВ. ОЙН ХӨНӨӨЛТ ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ГОЛОМТ, ТАРХАЛТТАЙ ТАЛБАЙГ ТОГТООХ, ТЭМЦЭЛ АЖИЛ ШААРДЛАГАТАЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭГ ТОГТООСОН АЖЛЫН ҮР ДҮН

ТАВ. ТЭМЦЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН СУДАЛГАА

1. Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн санд тэмцэл хийсэн ажлын явц, үр дүн
2. Богд Хан уулын ДЦГ-ын ойн санд тэмцэл хийсэн ажлын явц, үр дүн
3. Горхи Тэрэлжийн БЦГ-ы ойн санд хийсэн ажлын явц үр дүн
4. Тосон бэлдмэл туршсан ажлын явц

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ДОЛОО. АШИГЛАСАН НОМ, ЗҮЙ

ОРШИЛ

Манай улсад ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох ажил хийгдсэний дүнд навч, шилмүүсний хөнөөлт шавжийн тархалттай талбай 740.1 мянган га, үүнээс голомт үүссэн талбай 591.1 мянган га байгаа нь тогтоогджээ [Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох тоймчилсон судалгаа-2016. Ойн судалгаа, хөгжлийн төв].

Хөнөөлт зүйлийн хамгийн их тархалт, голомт бүхий аймгуудад Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай, Завхан, Хэнтий аймгууд ордог ба судалгааны дүнгээр Баруун Хангайн хошууны тайгархаг бүслүүр, Төв Хангайн хошууны тайгажуу бүслүүр, Баруун Хэнтийн хошууны тайгархаг бүслүүрийн ойн сан хөнөөлт шавжид их өртөж, тархалт элбэгшил өндөр байдаг. Хөнөөлт зүйлийн голомт талбай тайга, тайгажуу ой, тайгархаг ойн бүслүүрийн 1000-2400 метрийн өндрийн бүслүүрт 535.2 мянган.га-д (90.5%) тохиолддог. Хортон шавжийн тархалтын судалгааны ажил жил бүр 15-19 аймгийн ой бүхий сумдуудын нутагт хийгддэг ба бид зүүн бүсийн Хэнтий, Дорнод аймаг, Төв аймаг, Нийслэлийн ногоон бүс, Горхи Тэрэлж, Богдхан уулын ойн санд хөнөөлт зүйлийн тархалтын тандалтын судалгааг гүйцэтгэлээ.

Нийслэлийн ногоон бүсэд тэмцлийн ажил явуулах талбай сонгох судалгааны ажлыг тогтмол гүйцэтгэж ирсэн байдаг ба тухайлбал 2013 онд Улаанбаатар хотын ногоон бүс, Богдхан уулын ДЦГ-ийн ойн сангийн 53.8 мянган га буюу нийт 2.236.9 мянган га, 2014 онд 2.259.0 мянган га, 2015 онд 5 мянган га буюу нийт 2.009. мянган га, 2016 онд 2.607.4 мянган га, 2017 онд 2.981.5 мянган га, 2021 онд 80.0 мянган га ойн сан судалгаанд хамрагджээ. Харин 2023 онд мөн 81,4 мянган га ойн сан судалгаанд хамрагдлаа.

2023 онд бид 2 аймгийн 11 сум, Улаанбаатар хотын ногоон бүсийн ой, Богд Хан уулын ДЦГ, Горхи Тэрэлжийн БЦГ-ын 409,514 мян.га ойн сангийн талбайд навч, шилмүүсний хөнөөлт шавжийн тархалттай талбай 126,487 га илрүүлж, хөнөөлийн голомт үүссэн газрын хортны тархалтыг хязгаарлах, тоо толгойн нягтшилтыг бууруулах 2024 онд тэмцлийн ажил зайлшгүй явуулах шаардлагатай 42,425 га байгааг тогтоож ажиллаа.

Ойн хөнөөлт шавжийн хэт олшролыг эхэн үед нь илрүүлэх суурин цэгүүдийг байгуулан тогтмол судалгаа хийх, тэмцлийн ажилд химийн бодисын хэрэглээнээс бүрэн татгалзаж, бактерийн бэлдмэл хэрэглэх болон байгаль орчинд халгүй арга, технологийг нэвтрүүлснээр ойн хөнөөлт шавжийн байгалийн зохицуулагч шимэгч, махчин шавжууд хамгаалагдаж, байгалийн тэнцвэрт байдал хадгалагдах нь ой хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын үр дүн юм.

Гэрээт ажил гүйцэтгэх хугацааны үед ойн хөнөөлт шавжийн голомт үүсгэсэн талбайн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад зонхилох эрвээхэй тархалт ахисан түвшинд байгаа бөгөөд цаашид цаг уурын болон бусад хүчин зүйлээс шалтгаалан зарим зүйлийн хөнөөлт шавжийн голомт үүссэн талбайн хэмжээ Баруун, Зүүн Хэнтийн хошууны тайгархаг бүслүүрийн өсөх чиг хандлагатай байна.

НЭГ: ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

1. Хэнтий, Дорнод, Төв аймаг Улаанбаатар хотын ногоон бүс, БогдХан уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн ойн санд тархсан хөнөөлт шавж, өвчний төрөл зүйл, тархалт, нягтшлыг тодорхойлох
2. Хэнтий, Дорнод, Төв аймаг Улаанбаатар хотын ногоон бүс, БогдХан уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн ойн санд тархсан хөнөөлт зүйлийн эсрэг тэмцлийн ажил гүйцэтгэх талбай сонгох

1.2. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТ

Хэнтий, Дорнод, Төв аймаг Улаанбаатар хотын ногоон бүс, БогдХан уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ийн ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх авсан хуулийн этгээд НЯМЫН ӨНДӨР ХХК нь дээрх газар нутгийн ойн санд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний биологи экологийн онцлог, тархалт, нягтшлыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг тодорхойлон сонгох, тэмцлийн ажлын үр дүнгийн мониторингийн судалгааг 2023 оны 06 дүгээр сарын 10-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэнэ. Зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэх хугацааг төлөвлөн дараах хүснэгтээр харуулав (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэх хугацаа

Ойн санд ойн хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлог, тархалт, нягтшлыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох, тэмцлийн ажлын үр дүнг тооцох мониторингийн судалгаа хийх Ажлын төлөвлөгөөний төсөл 2023 (6-р сарын 10-нээс 2023 оны 10-р сарын 10)	Захирал (ЗА) Д.Ганбат Ерөнхий инженер (ЕИ) Г.Батсайхан Ойн шавж судлаач (ОШС) Б.Мөнхцэцэг Ойн аж ахуйн инженер(ОИ) О.Лхагважаргал Ойн мэргэжилтэн (ОМ)Д.Чимэгсанаа									
	Тайлан гаргах	Сарууд				Хэн хариуцах				Хугацаа
	4	5	6	7	8	9	10			
БЭЛТГЭЛ АЖИЛ										
• Арга зүйн дагуу ажлыг төлөвлөх								ЗА, ОШС	VI/5-VI/15	
• Ойн санд хийх ажлын судалгааны маршрут, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулах								ЗА, ЕИ, ОШС, ОМ	VI/15-VI/25	
МОНИТОРИНГИЙН СУДАЛГАА ХИЙХ АЖИЛ										
• Ойн санд тархсан, ойн хөнөөлт шавжийн тархалт, нягтшилыг тогтоох,								ЗА, ЕИ, ОШС, ОМ	VI/05-VI/15	
• Зарим хөнөөлт зүйлийн биологи, экологийн онцлогийг судлах,								ЗА, ЕИ, ОШС, ОМ	VI/05-X/10	
• Ойн өвчний ажиглалт хийх								ЗА, ЕИ, ОШС, ОМ,(ОИ)	VI/05-IX/20	
• Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох,								ЗА, ЕИ, ОШС,(ОИ)	VI/20-VI/20 VII/15-VIII/25	
• Феромонт урхи тавих								ЗА, ЕИ, ОШС,(ОИ)	VII/15	
• Тэмцлийн ажлын үр дүнг тооцох								ЗА, ЕИ, ОШС, ОМ	VI/15-VI/25 VII/25-IX/20	
• Явцын тайлан өгөх								ЗА, ЕИ, ОШС, ОМ	VI/10-VI/15	
МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХ										
• Ойн хөнөөлт шавжийн зүйлийн бүрдлийг тодорхойлох								ЗА, ОШС	VI/15-IX/15	
• Ойн өвчнийг тодорхойлох								ЗА, ОШС(ОИ)	VII/5-IX/10	
• Шавжид нэрвэгдсэн моддын диаметрийн өсөлтийг тодорхойлох								ЕИ, ОМ	VIII/25-IX/10	
• Феромонт урхинд баригдсан шавжийг тодорхойлох								ЗА, ОШС	VIII/25-IX/25	
• Судалгааны үр дүнд тулгуурлан нийслэлийн ногоон бүсийн ойд авч хэрэгжүүлэх ой хамгааллын арга хэмжээг төлөвлөх								ЗА, ЕИ, ОШС,(ОИ)	VI/25-X/10	
ТАЙЛАН БИЧИЖ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ АЖИЛ										
• Тайлан бичиж боловсруулах; Хүлээлгэж өгөх								ЗА, ЕИ, ОШС,ОМ	X/10-X/15	

Хүснэгт 2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

д/д	Нэр	Албан тушаал	Тайлан гаргах	Сарууд (хөндлөн зураасаар тэмдэглэх)								Сараар
				4	5	6	7	8	9	10	11	
1	Б.Мөнхцэцэг	Багийн ахлагч. Биологич, шавж судлаач. Доктор PhD			Yellow							7 сар
2	Г.Батсайхан	Ойн инженер Доктор PhD			Blue							7 сар
3	Д.Ганбат	Ойн шавж судлаач		Green								7 сар
4	О.Лхагважаргал	Ойн инженер			Green	Green		Green	Green	Green	Green	6 сар
5	Д.Чимэгсанаа	Мэргэжилтэн			Red			Red			6 сар	

Хүснэгт 3. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

	Үйл ажиллагаа (ажлууд)	Зөвлөхийн үйлчилгээ эхлэх болон гүйцэтгэх сарууд											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Бэлтгэл ажил												
	Ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах												
	Үе шатны ажлын хуваарь гаргах												
	Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аргачлалыг сонгох, танилцуулга бэлтгэх												
	Өмнөх жилүүдийн тайлан, материалтай танилцах												
	Багаж материал бэлтгэх (дээж авах сав, сачок, тоолуур, хямсаа, GPS, зургийн аппарат, дээжний уут, бийр, залуур зүү, скапель, шавжийн зүү, соруул)												
	Эм урвалж бэлтгэх (унтуулагч, хадгалагч бодис, ариутгалын бодис)												
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл бэлтгэх (маск, бээлий, малгай)												
2	Хээрийн судалгааны ажил												
	А.Хээрийн нөхцөлд байрлах майхан, гал тогооны хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах												
	Б.Хээрийн судалгааны ажилд гарах; Дээж материал цуглуулах, тооллого тооцоо хийх, тархалтын зураг гаргах, тэмцлийн ажил гүйцэтгэх голомт талбай сонгох, гүйцэтгэсэн ажлын акт үйлдэх, фото зураг авах												
	Ойн хөнөөлт шавжийн	1.Судалгаанд хамрагдсан газар нутгийн ойн санд тархсан хөнөөлт шавжийн зүйлийн бүрдлийг гаргах, тодорхойлох ажлын хүрээнд 2023 оны 06.10-06.20	-Нэг хэсэглэл буюу 500 га хүртэлх талбайд нэг дээж талбай сонгон хөнөөлт шавжийн зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох зорилгоор дээж цуглуулах <i>(Уусмалд болон хатаадас бэлтгэх аргаар) Шааж цуглуулах, боловсруулах, хадгалах стандартын хүрээнд, MNS 6724:2018</i>										
		2.Ойн хөнөөлт шавжийн тархалтын талбайн хэмжээг гаргах ажлын хүрээнд	-Хөнөөлт шавжийн зүйлийн бүрдлийг идэш тэжээлийн ангилалд оруулж жагсаалт гаргана										
			-Хөнөөлт зүйлийн тархсан талбайн хэмжээг ой зохион байгуулалтын материал ашиглан аймаг, сумын хэмжээнд хэсэглэл, ялгарлаар тооцож гаргах										
			-Тархалт элбэг, хөнөөлт зүйлийн тархсан талбайн зураглал хийх,										

	<p>6.Ойн хөнөөлт шавжийн тархалтын талбайн хэмжээг ой зохион байгуулалтын материал ашиглан аймаг, сумын хэмжээнд гаргах 2023 оны 06.25-10.15</p>				
	<p>7.2024онд хөнөөлт зүйлтэй тэмцэл явуулах төлөвлөгөө боловсруулах 2023 оны 10.15-10.25</p>	<p>1.Агаарын хөлгөөр тэмцэх шаардлагатай газар нутгийг</p>	<i>Ой зохион байгуулалтын материалаар;</i>		
		<p>2.Автомашин дээр тоноглогдсон ширшигч тоног төхөөрөмж, үүргийн шүршигч ашиглан тэмцэх шаардлагатай газар нутгийг</p>			
		<p>3.Механик аргаар тэмцэх шаардлагатай газар нутгийг</p>			
		<p>4.Гэрлэн урхи, феромонт урхи, наалдуулагч бүслүүр тавих шаардлага бүхий газар нутгийг тодорхойлж гаргах</p>			
<ul style="list-style-type: none"> Хэнтий аймгийн ойн санд хөнөөлт шавжийн тархалтын судалгаа хийх <ol style="list-style-type: none"> Хэнтий, Батширээт – 25000 га Хэнтий, Баян-Адрага- 20000 га Хэнтий, Биндэр- 28000 га Хэнтий, Дадал- 35000 га Хэтний, Өмнөдэлгэр- 12000 га Хэнтий, Норовлин- 5000 га Хэнтий, Цэнхэрмандал 40000 га Нийт 165000 га 					
<ul style="list-style-type: none"> Дорнод аймгийн ойн санд хөнөөлт шавжийн тархалтын судалгаа <ol style="list-style-type: none"> Дорнод, Баяндун- 6000 га Дорнод, Баян-уул- 8500 га Дорнод, Дашбалбар- 3000 га Нийт 17500 га 					
<ul style="list-style-type: none"> Улаанбаатар хотын ногоон бүс, Богдхан уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын ойн санд хөнөөлт шавжийн тархалтын судалгаа хийх <p>-Улаанбаатар хотын ногоон бүс- 70000 га -Горхи, Тэрэлжийн БЦГ- 15000 га</p>					
<ul style="list-style-type: none"> Төв аймгийн ойн санд хөнөөлт шавжийн тархалтын судалгаа хийх <ol style="list-style-type: none"> Төв, Батсүмбэр-33000 га Төв, Борнуур-10000 га Төв, Баяндэлгэр- 10000 га Төв, Мөнгөнморьт- 20000 га Төв, Баянчандмань- 6000 га Төв, Жаргалант- 5000 га Төв, Эрдэнэ- 28500 га нийт 112500 га 					

1.4. СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА

Ойн навч шилмүүсний хөнөөлт шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгой, зонхилон тархсан хөнөөлт зарим зүйлийн биологи-экологи ажиглалт, тархалт, тэмцэл хийх талбайн хэмжээ, газрын байршлыг тогтоох судалгааны ажлыг 2023 оны 06 сарын 05 -наас 07 сарын 20 хооронд хийж гүйцэтгэв.

1.5. СУДАЛГАА ХИЙГДСЭН ГАЗАР НУТАГ, ХЭМЖЭЭ

1. Хэнтий аймгийн ойн сан бүхий 7 сумын нутаг: **11 5549** га ойн сан (Батширээт Баян-Адрага Биндэр Дадал Норовлин Өмнөдэлгэр Цэнхэрмандал)
2. Төв аймгийн ойн сан бүхий 4 сумын нутаг: **60400** га ойн сан (Батсүмбэр, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баяндэлгэр)
3. УБ хотын ногоон бүсийн **28246** га ойн сан
4. Горхи Тэрэлжийн БЦГ-ийн **12000** га ойн сан
5. Богд Хан уулын **13000** га ойн сан



Зураг 1. Өвөр Хадатын ам, Сэлх. 2023 оны 07 сарын 10




2. Богд Хан уул, Төр хурхын ам 2023 оны 07 сарын 14



*Ы
н ам.2023 оны 07 сарын 14*



*а
н уул, Төр хурхын ам 2023 оны 07 сарын 5*



ан уул, Чулуут 2023 оны 07 сарын 8

Судалгаа хийгдсэн цэгүүд, байршил

Судалгаа, тэмцлийн ажлын мониторингийн ажил Хэнтий, Дорнод, Төв аймаг, Нийслэлийн ногоон бүс, Горхи Тэрэлжийн БЦГ, Богд Хан уулын ДЦГ-ын ойн сан бүхий 133 цэгт хийгдэв (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Нийслэлийн ногоон бүсэд судалгаа хийгдсэн газар, байршил


			*		"		*	'	"		ДТД
1	Багануур	Нарийны ам	47	51	40	47.86111111	108	14	6	108.235	1510
2	Багануур	Нүхэн зараа	47	52		47.86666667	108	13	21.4	108.2226111	1480
3	Гацуурт	Хуандай (Хадат)	47	56	36.3	47.94341667	107	14	11.2	107.2364444	1571
4	Гацуурт	Шижирийн даваа	48	0	50	48.01388889	107	17	19	107.2886111	1658
5	Гацуурт	Шижирийн даваа	48	0	41.7	48.01158333	107	17	16.2	107.2878333	1661
6	Гацуурт	Хуандай (Нүүрстэй)	47	58	25.6	47.97377778	107	17	19	107.2886111	1865
7	Гацуурт	Хуандай (Нүүрстэй)	47	58	25.6	47.97377778	107	17	27.8	107.2910556	1780
8	Гацуурт	Дээндий	47	51	12.4	47.85344444	107	21	19.7	107.3554722	1649
9	Гацуурт	Дээндий	47	51	36.3	47.86008333	107	17	0.7	107.2835278	1455
10	Гацуурт	Хуандай (Харанхуй)	47	0	39	47.01083333	107	18	45.1	107.3125278	1832
11	Гацуурт	Шар хоолой (Бэрхийн ар)	47	59	36.9	47.99358333	107	12	27.4	107.2076111	1600
12	Гацуурт	Шар хоолой (Найман шарга)	47	59	43.7	47.99547222	107	13	19.3	107.2220278	1647
13	Гацуурт	Шар хоолой (Найман шарга)	47	59	45.5	47.99597222	107	13	25.9	107.2238611	1658
14	Гацуурт	Шар хоолой (Хангалын эх)	47	3	42.9	47.06191667	107	17	2.2	107.2839444	1925
15	Гацуурт	Шар хоолой	47	4	14.9	47.07080556	107	14	16	107.2377778	1780
16	Гацуурт	Бага шар хоолой	48	1	8	48.01888889	107	11	45.3	107.1959167	1620
17	Гацуурт	Шар хоолой (Салхит)	47	3	28	47.05777778	107	14	44.7	107.24575	1715
18	Гацуурт	Шар хоолой (Шивэрт)	47	4	7.7	47.06880556	107	10	48.7	107.1801944	1959
19	Улиастай	Баянголын эх	48	5	38.7	48.09408333	107	9	43.2	107.162	1687
20	Улиастай	Богины ам	48	6	25.9	48.10719444	107	8	23.3	107.1398056	1861
21	Улиастай	Ар тарвагатай	48	5	37.2	48.09366667	107	7	3.1	107.1175278	1687
22	Улиастай	Өвөр тарвагатай	48	5	19.6	48.08877778	107	5	54.5	107.0984722	1670
23	Улиастай	Өвөр тарвагатай	48	5	55.9	48.09886111	107	5	57.9	107.0994167	1744
24	Улиастай	Шарын амны баруун	48	3	28.2	48.05783333	107	4	25.7	107.0738056	1578

		хойд									
25	Улиастай	Бөөгийн гацаа	48	2	59.9	48.04997222	107	3	35.1	107.05975	1510
26	Улиастай	Бөөгийн гацаа	48	2	51.6	48.04766667	107	3	36.7	107.0601944	1497
27	Бэлх	Хадат вилла	48	3	23.2	48.05644444	107	1	39.3	107.0275833	1838
28	Бэлх	Хадатын даваа	48	3	59.9	48.06663889	107	1	55.1	107.0319722	1913
29	Шар хоолой	Хадатын даваа	48	2	5.2	48.03477778	107	6	31.2	107.1086667	1636
30	Шар хоолой	Бумбатын ар	48	3	32.4	48.059	107	6	31.5	107.10875	1658
31	Шар хоолой	Бумбатын ар	48	4	12.2	48.07005556	107	6	43.4	107.1120556	1826
32	Шар хоолой	Бумбатын ар	48	4	6	48.06833333	107	6	50	107.1138889	1806
33	Улиастай	Шарын ам	48	3	13.8	48.05383333	107	6	31.2	107.1086667	1603
34	Шадивлан	Ойн жим	48	0	27.6	48.00766667	106	53	48.7	106.8968611	1530
35	Шадивлан	Ойн жим	48	0	27	48.0075	106	53	35.3	106.8931389	1535
36	Шарга морьт, хуурай мухар	-	48	4	8.1	48.06891667	106	54	59.1	106.9164167	1535
37	Шарга морьт, хуурай мухар	Хуурай мухар хад	48	4	34.5	48.07625	106	54	52.5	106.9145833	1580
38	Гоодой	Даваа	48	3	22.8	48.05633333	106	55	34.4	106.9262222	1542
39	Гоодой	-	48	2	19.8	48.03883333	106	55	25.1	106.9236389	1465
40	Гоодой	Дээд эх	48	2	20.7	48.03908333	106	57	3.1	106.9508611	1685
41	Сэлх	-	48	2	31.2	48.042	106	58	31.7	106.9754722	1646
42	Хотын ногоон бүс	Ар гүнт	48	24	90.6	48.42516667	106	56	19.2	106.9386667	
43	Хотын ногоон бүс	Бага баян	48	9	9.1	48.15252778	106	54	34.1	106.9094722	1629
44	Хотын ногоон бүс	Баруун салаа	48	1	40.2	48.02783333	106	47	24	106.79	1629
45	Хотын ногоон бүс	Баянголын ам	48	2	85.9	48.05719444	107	10	43.2	107.1786667	1448
46	Хотын ногоон бүс	Баян-Уул	48	2	9.1	48.03586111	106	47	18.7	106.7885278	
47	Хотын ногоон бүс	Баян хайрхан	48	1	42.9	48.02858333	106	49	15.3	106.8209167	1563
48	Хотын ногоон бүс	Бэлх	48	2	1.9	48.03386111	106	57	6.7	106.9518611	1600
49	Хотын ногоон бүс	Гоодой	48	2	29.6	48.04155556	106	54	55.4	106.9153889	1600
50	Хотын ногоон бүс	Жаргалантын ам	47	18	33.3	47.30925	101	55	95.9	101.9433056	1600
51	Хотын ногоон бүс	Жигжид	48	2	51.5	48.04763889	106	53	10.6	106.8862778	1600
52	Хотын ногоон бүс	Зуунмод	48	2	5.6	48.03488889	106	55	23	106.9230556	1600
53	Хотын ногоон бүс	Зүүнсалаа	48	1	21.2	48.02255556	106	48	59.2	106.8164444	1600
54	Хотын ногоон бүс	Их бага Эрэн	47	49	69.6	47.836	106	48	40	106.8111111	1600
55	Хотын ногоон бүс	Их баян	48	9	43.4	48.16205556	106	54	20.4	106.9056667	1600

56	Хотын ногоон бүс	Их хадат	48	0	49.7	48.01380556	106	49	36.2	106.8267222	1600
57	Хотын ногоон бүс	Майхан толгой	48	5	58.4	48.09955556	106	53	2.2	106.8839444	1296
58	Хотын ногоон бүс	Нарс зуслан	48	2	63.4	48.05094444	106	47	77.5	106.8048611	
59	Хотын ногоон бүс	Онгоцтой хад	48	8	13.4	48.13705556	106	53	52.7	106.8979722	
60	Хотын ногоон бүс	Өвөр тарвагатай	48	5	20.4	48.089	107	5	46.2	107.0961667	
61	Хотын ногоон бүс	Хадат даваа	48	3	47.4	48.06316667	107	2	20.3	107.0389722	
62	Хотын ногоон бүс	Халзан даваа	48	10	27.8	48.17438889	106	49	40.7	106.8279722	
63	Хотын ногоон бүс	Хандгайт	48	7	45.4	48.12927778	106	58	5.7	106.96825	
64	Хотын ногоон бүс	Шадивлан	48	0	29	48.00805556	106	53	29.6	106.8915556	
65	Хотын ногоон бүс	Шар хоолой	48	3	6.7	48.05186111	107	16	49.6	107.2804444	
66	Хотын ногоон бүс	Шарын ам	48	7	37.8	48.12716667	107	5	34	107.0927778	
67	Хотын ногоон бүс	Шивэртийн ам	48	4	94.8	48.093	107	10	28.1	107.1744722	
68	Хотын ногоон бүс	Шижирийн ам	48	1	16.5	48.02125	107	15	18.9	107.25525	
69	Хотын ногоон бүс	Яргайт	48	1	56.6	48.03238889	106	53	20.4	106.889	
70	Биндэр	Шаазгайн эх	48	35		48.58333333	110	29	48	110.4966667	
71	Биндэр	Шаазгайн адаг	48	35		48.58333333	110	31	44	110.5288889	
72	Биндэр	Онон голын шугуй	48	35	43.9	48.59552778	110	42	30.8	110.7085556	
73	Биндэр	Бирвааз	48	35	51.5	48.59763889	110	43	32	110.7255556	
74	Биндэр	Хурхын боом	48	35	52.6	48.59794444	110	43	41.2	110.7281111	
75	Биндэр	Арал	48	36	46.5	48.61291667	110	37	33.9	110.6260833	
76	Биндэр	Дөрвөн модны ам	48	34	27.2	48.57422222	110	27	6.8	110.4518889	
77	Биндэр	Буурлын давааны ар	48	35	19.7	48.58880556	110	29	49.8	110.4971667	
78	Биндэр	Дунд баян	48	23	38.2 85	48.393968	110	15	41.91	110.261642	
79	Биндэр	Азарган Даваа	48	26	25.7	48.44047222	110	46	22.07	110.7727972	
80	Биндэр	Таван мод	48	37	0.92 28	48.616923	110	28	27.58	110.474327	
81	Биндэр	Баян гол	48	7	37.8 05	48.127168	109	22	44.5	109.379029	
82	Баян-Адарга	Оногийн бургас	48	41		48.68333333	111	15	19	111.2552778	
83	Баянадрага	Дамба	48	33	19.6	48.55544444	111	1	80.9	111.0391389	
84	Баянадрага	Бирвааз	48	41	5.4	48.68483333	111	14	53.3	111.2481389	ft 3760
85	Баянадрага	Онон голын шугуй	48	55	34.8	48.92633333	111	35	30	111.5916667	ft 3050
86	Баянадрага	Дамба	48	33	44.7	48.56241667	111	2	20.5	111.0390278	
87	Баянадрага	Өлийн даваа	48	35	56.4	48.599	111	14	49.6	111.2471111	ft 3150
88	Далал	Ганцогийн зүүн хойд давааны ар	48	48		48.8	111	47	32	111.7922222	

89	Дадал	Эрээн ар	48	53	6.8	48.88522222	111	20	7.2	111.3353333	
90	Дадал	Баруун шанд	48	53	52.2	48.89783333	111	25	15.4	111.4209444	
91	Дадал	Асгатын ар	48	54	57.8	48.91605556	111	30	13.6	111.5037778	
92	Дадал	Асгат	48	55	33.1	48.92586111	101	30	30.8	101.5085556	ft 3110
93	Цэнхэр мандал	Бор хужиртын давааны урд ар	47	45		47.75	108	50	43	108.8452778	ft 5450
94	Цэнхэр мандал	Замчдын овооны урд ар	47	44	8.7	47.73575	108	54	6.3	108.90175	
95	Цэнхэр мандал	Шивэрт	47	57	4.4	47.95122222	108	57	41	108.9613889	
96	Цэнхэр мандал	Бор хужирын улаан чулаат	47	43	39.2	47.72755556	108	54	27.3	108.9075833	
97	Цэнхэр мандал	Уртын ам	47	52	36.1	47.87669444	109	2	8.6	109.0357222	
98	Цэнхэр мандал	Яргайт	48	43	45.2	48.72922222	108	36	77.1	108.6214167	
99	Цэнхэр мандал	Юдэгийн доод үзүүр	45	57	15.4	45.95427778	108	42	58.2	108.7161667	1615m.
100	Цэнхэр мандал	Юдэг таван толгой	45	58	25.8	45.97383333	108	48	12.9	108.8035833	1615m
101	Цэнхэр мандал	Таван толгой	45	58	29.3	45.97480556	108	48	12.3	108.8034167	1547m.
102	Цэнхэр мандал	Хөх нуураас урагш	47	58	4.8	47.968	108	58	32.6	108.9757222	1575m
103	Цэнхэр мандал	Хөх нуураас урагш Мойлт	47	57	0.5	47.95013889	108	58	0.4	108.9667778	1591m
104	Цэнхэр мандал	Согоотын харалдаа, зүүн тал	47	57	0.5	47.95013889	108	58	0.4	108.9667778	1591m.
105	Цэнхэрмандал	Хуурай	47	51	41	47.86138889	108	56	37.8	108.9438333	1471m.
106	Цэнхэрмандал	Огзомын давааны ар	47	41	10.8	47.68633333	108	56	35.7	108.94325	1643m.
107	Цэнхэр мандал	Хорхойн даваа	47	41	10.9	47.68636111	108	56	35.9	108.9433056	1629m.
108	Жаргал тхаан	Баруунбаян	47	43	50.7	47.73075	109	29	11.2	109.4864444	1452m
109	Батширээт	Живхээстэй зүүн тал	48	43	18.7	48.72186111	110	3	14.1	110.0539167	
110	Өмнөдэлгэр	Хангалын эх	48	56	15.1	48.93752778	103	24	17.9	103.4049722	
111	Өмнөдэлгэр	Баруун юит	48	58	28.3	48.97452778	103	4	44.1	103.0789167	
112	Өмнөдэлгэр	Залаатын баруун үзүүр	48	0	55.9	48.01552778	109	27	35.9	109.4599722	
113	Төв. Батсүмбэр	Цогт-Өндөр	48	31	13	48.52027778	106	49	51.9	106.8310833	
114	Төв. Батсүмбэр	Энхтайван	48	33	37.5	48.56041667	106	49	24.9	106.8235833	
115	Төв. Батсүмбэр	Тусгалт	48	33	38.6	48.56072222	106	59	47.2	106.9964444	
116	Төв. Батсүмбэр	Хар бэлчир	48	33	41.7	48.56158333	107	1	49.7	107.0304722	

117	Төв. Батсүмбэр	Нарийн гацууртын ам	48	34	14.2	48.57061111	106	51	19.5	106.8554167
118	Төв. Баяндэлгэр	Дуутын ам	47	53	35.3	47.89313889	108	08	1.5	108.13375
119	Төв. Баяндэлгэр	Хэнтий жалга	47	53	7.2	47.88533333	108	9	42.6	108.1618333
120	Төв. Баяндэлгэр	Шулгуут	47	54	55	47.91527778	108	11	24.9	108.19025
121	Төв. Баяндэлгэр	Хурцын өвөр	47	56	25.2	47.94033333	108	5	33.1	108.0925278
122	Төв. Баяндэлгэр	Баруун байдлаг	47	58	27.4	47.97427778	107	10	27.3	107.17425
123	Төв. Мөнгөнморьт	Зүүн байдлаг	48	8	23.4	48.13983333	108	26	32.9	108.4424722
124	Төв. Мөнгөнморьт	Урд байдлаг	48	0	55.8	48.0155	108	23	52.2	108.3978333
125	Төв. Мөнгөнморьт	Дунд байдлаг	48	2	15.1	48.03752778	108	24	47.7	108.41325
126	Төв. Мөнгөнморьт	Тосон	48	8	55.4	48.14872222	108	26	7.4	108.4353889
127	Төв. Мөнгөнморьт	Овоон дэнж	48	13	15.9	48.22108333	108	29	51	108.4975
128	Төв. Мөнгөнморьт	Дэнслэг	48	15	28.7	48.25797222	108	30	42.2	108.5117222
129	Төв.Эрдэнэ	Ар горхийн адаг	47	48	55.7	47.81547222	107	5	13.7	107.0871389
130	Төв.Эрдэнэ	Элстэй	47	44	9.9	47.73608333	107	35	44.4	107.5956667
131	Төв.Эрдэнэ	Сэрүүн	47	45	53.5	47.76486111	107	48	50.8	107.8141111
132	Төв.Эрдэнэ	Баян давааны ар	47	46	18.2	47.77172222	107	37	54.7	107.6318611
133	Төв.Эрдэнэ	Ар мухар	48	2	36.7	48.04352778	107	33	1.1	107.5503056



Зураг 6. Судалгаа хийгдсэн цэгүүдийг газар дүрсийн зураг дээр харуулбал

ХОЁР. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1. ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ, ТАРХАЛТЫГ ТОГТООХ АЖЛЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЛЭГДСЭН БАГАЖ, МАТЕРИАЛ

Судалгаа хийсэн цэгүүдийг тухайн газар нутгийг хариуцан ажилладаг байгаль хамгаалагчдын санал болон ойн ерөнхий төлөв байдлыг харж сонгов. Судалгааны ажилд удирдлага болгож ашигласан арга зүй, стандарт:

1. Тэмцлийн ажлын үр дүнг тооцох, ойн хөнөөлт шавьж, өвчний тархалт голомтыг тогтоох, хөнөөлт шавжтай тэмцэл хийснээр шавжийн бүлгэмдэлд үзүүлэх нөлөөг мониторингоор судлах арга зүй. Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачлага. ТББ (УХЭШХ. Протокол №2. 01.20.2011).
2. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх аргыг боловсронгуй болгох, үр дүнг тооцох арга зүй боловсруулах. Зөвлөх үйлчилгээний (ОСХТ-2013.ОХҮНСА-22) гэрээт ажлын тайлан. Ерөнхий болон Сорилын Биологийн хүрээлэн. Шавж судлалын лаборатори.
3. Методы мониторинга вредителей и болезней леса . Федеральное агенство лесного хозяйство. Справочник. Том-3.2004
4. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага. MNS 6532:2015
5. Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тодорхойлох судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага. MNS 6533:2015
6. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага. MNS 6534:2015
7. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх микробиологийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага. MNS 6535:2015
8. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх химийн аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага. MNS 6536:2015
9. Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага. MNS 6537:2015.

Судалгааны ажлын явцад үндсэн 4 арга ашиглаж тооцоо, судалгаа хийв. Үүнд:

1. Шавж илрүүлэх, тооны нягтшилыг тогтоох “мод доргиох” арга хэрэглэв.
2. Тооллого хийх, дээж цуглуулав.
3. Модонд үзлэг хийж, дээж авч, зураг авлаа- MNS 6533:2015
4. Шавжийн дээжийг “Шавж цуглуулах, боловсруулах, тодорхойлох, хадгалах арга” MNS 6724:2018 стандартын дагуу болон тодорхойлох бичиг ашиглан зүйлийг тогтоов.



Зураг 7 Дээжний сав



Зураг 8. Амьд тээвэрлэгч



Зураг 9.Томруулагч




Зураг 10. Гар микроскоп



Зураг 11. Шавж тоологч



Зураг 12. Шавжийн соруул



Зураг 13. Залуур зүү, хямсаа, соруул



Зураг 14. Электрон штангенциркуль

2.2. СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ойн хөнөөлт шавжийн төрөл зүй, тархалтын судалгаа, тэмцэх арга хэмжээ явуулах талбай сонгох ажлыг эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид, хувийн хэвшлийн компанийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр холбогдох орон нутгуудын байгаль орчны газрын удирдлага, мэргэжилтнүүд, байгаль хамгаалагч нарын туслалцаатайгаар ойн хортны тархалт, хөнөөл ихтэй төлөөлөх цэгүүдэд ажиллалаа. Судалгааг ой хамгаалал, ойжуулалтын ажлыг тухайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа Нямын Өндөр ХХК-ны инженер, судлаачид гүйцэтгэв.

Багийн гишүүд:

- Биологич, Шавж судлаач. Д.Ганбат
- Биологич, Шавж судлаач. Б.Мөнхцэцэг
- Ойн аж ахуйн инженер. Г.Батсайхан
- Ойн аж ахуйн инженер. О.Лхагважаргал
- Нямын өндөр ХХК-ны ажилтан Д.Чимэгсанаа
- МУИС-ийн Хэрэглээний ШУ-ны сургуулийн Ойн аж ахуйн хөтөлбөрийн оюутан Г.Баясгалан, Б. Сондор, Г.Ган-эрдэнэ.

Захирал Д.Ганбат ойн шавжийн тархалт, хор хөнөөл, өсөлт хөгжлийн зүй тогтолыг тогтоох, тэдгээртэй тэмцэх чиглэлийн судалгааг гүйцэтгэдэг. Инженер Г.Батсайхан нь байгалийн болон таримал ойн өсөлт, хөгжилт, түүний онцлогийн судалгааг Б.Мөнхцэцэг ойн хөнөөлт шавжийн хэт олшролын цаашдын чиг хандлага, тэмцэх арга технологийн судалгааны ажлыг гүйцэтгэдэг.

**Хүснэгт 5. АЖЛЫН ХУВААРИЛАЛТ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ШААРДЛАГАТАЙ
ЧАДВАРЫН ТҮВШИН**

Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил
Д.Ганбат	Захирал Биологич, Шавж судлаач	Хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлогийг судлах, төрөл зүйл тодорхойлох, тооны нягтшил, хөгжлийн эргэлт, тооны хөдлөл зүй, олшролын үе шатыг тодорхойлох, тэдгээртэй тэмцэх аргын чиглэлээр ажилласан 30 жилийн ажлын туршлагатай	<p>Удирдлага Зөвлөх үйлчилгээний багцийн судалгааны ажлыг удирдлагаар хангах, зохион байгуулах -Ажлын төлөвлөгөө, хөтөлбөр батлах -Үе шатны ажлын хуваарь батлах - Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аргачлалыг сонгох, танилцуулга батлах -Хэнтий, Дорнод аймгийн ойн санд хөнөөлт шавжийн тархалтын судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах</p> <p>-Түгээмэл тохиолдоцтой хөнөөлт зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, экологийн зарим онцлог, хөгжлийн үе шатыг судлах, тооны нягтшил, хэт олшролын өнөөгийн байдал, өсөлтийн динамик, цаашдын хандлагыг тодорхойлно. - Дээж материалд боловсруулалт хийх - Тодорхой бус зүйлийг лабораторид түлхүүр бичиг ашиглан төрөл, зүйлийн түвшинд тодорхойлно</p> <p>-Хөнөөлт зүйлийн фенологи, биологи экологийн онцлог, цаг уурын нөлөө, паразит зүйлийн халдварлалтын ажиглалт хийх, феромонт урхи байрлуулж ажиглах. - Хээрийн судалгааны тоон материалд боловсруулалт хийх - Цаг уурын мэдээнд боловсруулалт хийж дүгнэлт гаргах - Тайлан хэлэлцүүлж хүлээлгэн өгөх</p>
Б.Мөнхцэцэг	Багийн ахлагч Биологич, Шавж судлаач	Хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлогийг судлах, төрөл зүйл тодорхойлох, тооны нягтшил, хөгжлийн эргэлт, тооны хөдлөл зүй, олшролын үе шатыг тодорхойлох, тэдгээртэй тэмцэх аргын чиглэлээр ажилласан 30 жилийн ажлын туршлагатай	<p>Судалгааны ажлын багийн ахлагч Ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах -Үе шатны ажлын хуваарь гаргах - Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аргачлалыг сонгох, танилцуулга бэлтгэх -Нийслэлийн ногоон бүс, Горхи тэрэлжийн БЦГ, Төв аймгийн ойн санд хөнөөлт шавжийн тархалтын судалгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах -Түгээмэл тохиолдоцтой хөнөөлт зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, экологийн зарим онцлог, хөгжлийн үе шатыг судлах, тооны нягтшил, хэт олшролын өнөөгийн байдал, өсөлтийн динамик, цаашдын хандлагыг тодорхойлно. -Хөнөөлт зүйлийн фенологи, биологи экологийн онцлог, цаг уурын нөлөө, паразит зүйлийн халдварлалтын ажиглалт хийх, феромонт урхи байрлуулж ажиглах. - Хээрийн судалгааны тоон материалд боловсруулалт хийх - Цаг уурын мэдээнд боловсруулалт хийж дүгнэлт гаргах - Дээж материалд боловсруулалт хийх - Тодорхой бус зүйлийг лабораторид түлхүүр бичиг ашиглан төрөл, зүйлийн түвшинд тодорхойлно</p>

Г.Батсайхан	Ойн инженер, судлаач	Ойжуулалт, ой нөхөн сэргээлтийн чиглэлээр 16 жил ажиллаж мэргэшсэн	<p>Ойн хээрийн хэмжилтийн судалгааны багийн ахлах инженер</p> <ul style="list-style-type: none"> -Талбайг ой зохион байгуулалтын материалын хэсэглэл, ялгарлаар аймаг, сум тус бүрээр гаргана. -Судалгааны дүнд хөнөөлт шавж, өвчний тархалт, голомт, хөнөөлийн голомт, дахин сэргэх чадваргүй болсон талбайг тогтооно. <i>Ой зохион байгуулалтын материал ашиглан;</i> -Агаарын хөлгөөр тэмцэх шаардлагатай газар нутгийг - Автомашин дээр тоноглогдсон ширшигч тоног төхөөрөмж, үүргийн шүршигч ашиглан тэмцэх шаардлагатай газар нутгийг - Механик аргаар тэмцэх шаардлагатай газар нутгийг -Гэрлэн урхи, феромонт урхи, наалдуулагч бүслүүр тавих шаардлага бүхий газар нутгийг тодорхойлж гаргах - Хөнөөлт зүйлийн тархсан талбайн хэмжээг ой зохион байгуулалтын материал ашиглан аймаг, сумын хэмжээнд хэсэглэл, ялгарлаар тооцож гаргах - Тархалт элбэг, хөнөөлт зүйлийн тархсан талбайн зураглал хийх
О.Лхагва-жаргал	Ойн инженер, судлаач	Ой зохион байгуулалтын тандан судалгаа, зураглал, ойжуулалтын чиглэлээр 6 жил ажиллаж мэргэшсэн	<p>Ойн шавжийн голомтын талбайг тогтоох, зураглал хийх багийн инженер</p> <ul style="list-style-type: none"> -Талбайг ой зохион байгуулалтын материалын хэсэглэл, ялгарлаар аймаг, сум тус бүрээр гаргана. -Судалгааны дүнд хөнөөлт шавж, өвчний тархалт, голомт, хөнөөлийн голомт, дахин сэргэх чадваргүй болсон талбайг тогтооно. <i>Ой зохион байгуулалтын материал ашиглан;</i> -Агаарын хөлгөөр тэмцэх шаардлагатай газар нутгийг - Автомашин дээр тоноглогдсон ширшигч тоног төхөөрөмж, үүргийн шүршигч ашиглан тэмцэх шаардлагатай газар нутгийг - Механик аргаар тэмцэх шаардлагатай газар нутгийг -Гэрлэн урхи, феромонт урхи, наалдуулагч бүслүүр тавих шаардлага бүхий газар нутгийг тодорхойлж гаргах - Хөнөөлт зүйлийн тархсан талбайн хэмжээг ой зохион байгуулалтын материал ашиглан аймаг, сумын хэмжээнд хэсэглэл, ялгарлаар тооцож гаргах - Тархалт элбэг, хөнөөлт зүйлийн тархсан талбайн зураглал хийх
Д.Чимэгсанаа	Туслах ажилтан	Химич. Ойн судалгааны ажлын туслах ажилтны 8 жилийн туршлагатай. Химийн бодис, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэшсэн.	<ul style="list-style-type: none"> -Багаж материал бэлтгэх (дээж авах сав, сачок, тоолуур, хямсаа, GPS, зургийн аппарат, дээжний уут, бийр, залуур зүү, скапель, шавжийн зүү, соруул) - Эм урвалж бэлтгэх (унтуулагч, хадгалагч бодис, ариутгалын бодис) - Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл бэлтгэх (маск, бээлий, малгай) - Хээрийн нөхцөлд байрлах майхан, гал тогооны хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах

Хүснэгт 6. Судалгааны ажилд хамтран оролцогчид

№	Судалгаанд хамрагдсан газрууд	Судалгаанд хамтран оролцогчид
1	Багануур дүүрэг.1-р хороо	Байгаль хамгаалагч Д.Ганбат
2	Баянзүрх дүүрэг, Улиастай, Баянзүрх, Бэлх, Сэлх	Байгаль хамгаалагч Г.Дэмбэрэл О. Азаяа, Цогтбаатар, Жаргалсайхан, Нацагдорж, Х.Чингис, В.Бүрнээбазар,
3	-Сонгино хайрхан дүүрэг 34-р хороо, Баянголын ам -Сонгино хайрхан дүүргийн 42-р хороо, Зүүнсалаа, Баруунсалаа	Байгаль хамгаалагч Б.Отгонбаяр, С.Ганчөдөр, Н.Дүгэрсүрэн, Д.Төмөрбаатар, Ц. Даваадорж, Д.Магнай, Д.Энхбаатар
4	Зуслангийн бүс, Гүнт, Гачуурт тосгон	Ц. Цогтбаатар, Н.Бямба, Г. Жаргалсайхан С.Хүрэлсүх Х.Нацагдорж, Б.Борбаатар Г.Энхболд ЗГХАгентлаг Ойн газар ахлах мэргэжилтэн
5	Дорнод Баян уул, Баян дун	Сум дундын ойн ангийн дарга, н. Эрдэнэбилэг, инженер Оюунтөгс, Байгаль хамгаалагч: С.Болдбаатар Иргэн Ц.Батзориг, Д.Бямбаа
6	Хэнтий, Өмнөдэлгэр	Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга, н. Мөнх-очир, инженер Б.Доржпүрэв Байгаль хамгаалагч: С.Болдбаатар Иргэн Ц.Чулуунбат, С.Амар
7	Хэнтий, Цэнхэрмандал	Байгаль хамгаалагч: Ж.Тодбилэг
8	Хэнтий, Жаргалтхаан сум	Идэвхтэн байгаль хамгаалагч: Б. Доржпүрэв
9	Хэнтий, Батширээт сум	Сум дундын ойн ангийн мэргэжилтэн О.Биндэрья, А.Отгончимэг Байгаль орчны улсын байцаагч Б. Мөнх-Очир Байгаль хамгаалагч Б. Болд Иргэн Б.Энх-Амгалан, С.Давааням, Ц.Содномдамба, Л. Энхтөр, Л.Мөнхтөр, Л.Отгонбаяр
10	Хэнтий, Биндэр	Ойн ангийн дарга Даваажаргал, инженер Байгаль орчны улсын байцаагч Г. Цэдэвсүрэн Байгаль хамгаалагч Ч. Оюунбат
11	Хэнтий, Баян Адрага	Засаг даргын орлогч Н. Анхбаяр Багийн засаг дарга Х.Ганболд Хот тохижилтын дарга Л.Баярхүү Байгаль орчны улсын байцаагч О.Батсуурь
12	Хэнтий, Дадал	Багийн дарга А.Азжаргал байгаль хамгаалагч Ц.Оргил байгаль хамгаалагч Ц.Онон байгаль хамгаалагч Г.Баярмагнай хуулийн мэргэжилтэн Л. Азжаргал Иргэн А.Мөнх-Алдар, Б, Бямбадэлгэр
13	Хэнтий, Норовлин	Байгаль орчны улсын байцаагч Г. Мөнхзул Баян нөхөрлөлийн ахлагч Б. Энх-Амгалан Баян нөхөрлөлийн гишүүн Б. Энхбаатар Баян нөхөрлөлийн гишүүн Д. Батбаяр Жаргалант багийн засаг дарга: Г:Оюунчимэг
14	Төв, Мөнгөнморьт	Багийн засаг дарга Э.Дулам Байгаль хамгаалагч С.Дашчойлон

		Сум дундын ойн ангийн инженер Бямбаа
15	Төв, Баяндэлгэр	Байгаль хамгаалагч Б.Өлзий Иргэн Г.Гантулга, Д. Наранбаатар, Б.Саруулбуян
16	Төв, Батсүмбэр	Сум дундын ойн ангийн дарга Ц. Гантулга Сум дундын ойн ангийн мэргэжилтэн Б.Аззаяа
17	Төв, Борнуур	Борнуур сумын тамгын дарга:Т.Өлзийбуян, иргэн Б.Энхбаяр
18	Горхи Тэрэлжийн БЦГ	Б.Сарантуяа ЗГХАгентлаг Ойн газар мэргэжилтэн, БЦГ-ийн мэргэжилтэнгүүд, байгаль хамгаалагчид
19	Богд Хан уулын ДЦГ	Г. Энхболд ЗГХАгентлаг Ойн газрын ахлах мэргэжилтэн, ДЦГ-ийн мэргэжилтэн Бүтэнсайн, байгаль хамгаалагч, Ж. Өсөхбаяр, Г. Барайшир, Н. Олз, Батжаргал, Н.Даваадалай, Б.Батбаатар, Байгаль орчны улсын байцаагч Ю.Ядамсүрэн, Н.Саруул, Тогтохбаяр, Монтаксац ХХК захирал Б.Гэрэл, инженер Н. Мягмаржав, Хүрхрээ ХХК-ны менежер Д.Энхтуяа

ҮЙЛ , АЖЛЫН ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

1. Ажлын төлөвлөгөө боловсруулж, судалгааны маршрут гаргаж ажиллаж, судалгааны арга зүйн дагуу ажиллав.
2. Багаж, материал, эм урвалжийн бэлэн байдлыг хангаж, бэлэн болгож, машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллав.
3. Орон нутгийн байгаль хамгаалагчдад судалгаанд гарахыг урьдчилан мэдэгдэж, аймаг, сумд, нийслэлийн байгаль орчны газрын мэргэжилтэн нартай уулзан ажлын төлөвлөгөөгөө танилцуулж, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран ажиллав.
4. Хөнөөлт шавжийн төрөл зүйлийг бүртгэх, тархалт, нягтшлыг тогтоох ажлыг арга зүйн дагуу гүйцэтгэн, ойн хортон бүхий цэгүүд дээр ажиллаж дээж, материал цуглуулан, тооллого бүртгэл, ажиглалт хийж фото зураг авлаа
5. Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нараас хөнөөлт ажлын судалгаа болон тэмцлийн ажилтай холбоотой санал авлаа.
6. Тэмцлийн ажил гүйцэтгэх талбайн сонголт хийж, ой зохион байгуулалтын зураг дээр ажиллав.
7. Ойн хөнөөлт шавжийн олшрол, тархалт, нягтралын судалгааг Нямын өндөр ХХК-ны захирлын баталсан төлөвлөгөөний дагуу ажиллав.
8. Тэмцлийн ажил гүйцэтгэх цэгийг судалгаанд хамрагдсан орон нутгуудын мэдээлэл, судалгааны ажил, байгаль хамгаалагчдын саналыг үндэслэн сонгосон.
9. Судалгаа хийгдсэн газар нутагт навч, шилмүүсний хөнөөлт шавж, өвчний тархалтыг тогтоохоор дээж талбай байгуулан, батлагдсан арга зүйн дагуу тооллого, хэмжилт явуулан үр дүнг нэгтгэн гаргалаа.
10. Судалгаанд 2ы аймгийн 11 сум, Улаанбаатар хотын ногоон бүсийн ой, Богд Хан уулын ДЦГ, Горхи Тэрэлжийн БЦГ-ын **237395 мян.га** ойн сангийн талбай хамрагдсанаас навч, шилмүүсний хөнөөлт шавжийн голомттой талбай 114420 га, нарсны энгийн шютте (*Lophodermium pinastri*) өвчин бүхий 9460 га-г илрүүлж, хөнөөлийн голомт үүссэн газрын хортны тархалтыг хязгаарлах, тоо толгойн нягтшилтыг бууруулах тэмцлийн ажил зайлшгүй явуулах шаардлагатай **84610 га** байгааг тогтоолоо.
11. Ойн санд Шинэсний нахианы урын ялаа (*Dasyneura laricis*), Сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus sibiricus*), Өрөөсгөл хүр эрвээхэй (*Lymanthria dispar*), Бургасны хүр эрвээхэй (*Leucoma salicis*), Эгэл бийрэн сүүлт эрвээхэй (*Orgyia antiqua*), Якобсоны төөлүүрч эрвээхэй (*Erannis jacobsoni*), Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй (*Zeiraphera diniana*) зэрэг хөнөөлт зүйлүүдийн тархалтыг аймаг сум тус бүрээр ой зохион байгуулалтын материал ашиглан гаргав.

Хүснэгт 7. Нийт тэмцэл явуулах талбайн хэмжээ, га

Газрын нэр	Тэмцэл явуулах талбай,га
1. Хэнтий	35310
2. Төв аймаг	21200
3. УБ хотын ногоон бүсийн ойн сан	16200
4. Горхи Тэрэлжийн БЦГ-ийн ойн сан	5800
5. Богд Хан уулын ойн сан	6100
Нийт	84610 га



Зураг15-16. Нэг модон дээрх хортны тооны нягшилыг тооцоолох ажлын явц



Зураг 17-18. Ажлын явцыг харуулбал



Зураг 19-21. Судалгаанд оролцсон байгаль хамгаалагчид



Зураг 22-24. Тэмцлийн дараах судалгааны ажлын явц



Зураг 25-26. Ажлын явц, багийн бүрэлдэхүүн

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

3.1.СУДАЛГААНЫ ХУГАЦААНД БҮРТГЭГДСЭН ХӨНӨӨЛТ ШАВЖИЙН ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хэнтий, Дорнод, Төв аймаг, Нийслэлийн ногоон бүс, Богд Хан-уул ДЦГ-ын, Горхи Тэрэлжийн БЦГ-ын ойн санд 2023 онд тархсан ойн хөнөөлт зарим навч шилмүүсний хөнөөлт шавжийн төрөл, зүйлийн жагсаалт:

Хайрсан далавчит баг (Lepidoptera)

1.Овог: *Lasiocampidae*

Зүйл: Сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus sibiricus* Tschetverikov.1908)

2.Овог : *Tortricidae*

Зүйл: Шинэсний шилмүүс хуйлагч (*Zeiraphera diniana* Gn, 1799)

3.Овог: *Geometridae*

Зүйл: Якобсоны төөлүүрч эрвээхэй (*Errannis jacobsoni* Djakonov.1926)

4.Овог: *Erebidae*

Зүйл: Эгэл бийрэн сүүлт эрвээхэй (*Orgyia antiqua* Linnaeus, 1758)

5.Овог: *Erebidae*

Зүйл: Нарсны бийрэн сүүлт эрвээхэй (*Orgyia pseudotsugata* McDunnough, 1921)

6. Овог: *Erebidae*

Зүйл: Бургасны хүр эрвээхэй (*Leucoma salicis* Linnaeus, 1758)

7.Овог: *Erebidae*

Зүйл: Өрөөсгөл хүр эрвээхэй (*Lymantria dispar* Linnaeus, 1758)

8. Овог: *Yponomeutidae*

Зүйл: Моносны хивэн эрвээхэй (*Yponomeuta padella* Linnaeus, 1758)

Сарьсан далавчитны баг (Hymenoptera)

1.Овог: *Tenthredinidae*

Зүйл: Шинэсний хярга (*Pristiphora erichsonii* Harting, 1837)

Хатуу далавчитны баг (Coleoptera)

1. Овог: *Chrysomelidae*

Зүйл: Навчит модны навчит цох (*Phratora laticollis* Suffrian, 1851)

2. Овог: *Scolytidae*

Зүйл: Шинэсний холтосч цох (*Ips subelongatus* Motschulsky, 1860)

Хос далавчитны баг (Diptera)

1. Овог: *Cecidomyiidae*

Зүйл: Шинэсний нахианы урч ялаа (*Dasyneura laricis*, F.Loew)

Дээрх судалгаа хийгдсэн газар нутгийн ойн санд хайрсан далавчитны багийн 4 овгийн 6 зүйл

эрвээхэй, хос далавчитны 1 овгийн 1 зүйл ялааны тооны олшрол, нягтшил өндөр байж, элбэг тохиолдоцтой байв.

2023 оны хаврын тандалтын судалгаагаар Хэнтийн аймгийн Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Баян-Адрага, Цэнхэрмандал сумдын ойн сан, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдын ойн санд Шинэсний нахианы урын ялаа, Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй голомт үүсгэн, ойг өнгөний хувиралд оруулснаас ихэнх ойн сэргэлт бага, улайсан, хаталт явагдсан байдалтай байна. Эдгээр аймаг сумдын ойн санд Сибирийн хүр эрвээхэй, Якобсоны төөлүүрч эрвээхэй, Өрөөсгөл хүр эрвээхэйнүүд тогтмол голомт үүсгэдэг онцлогтой.



Зураг 27. Шинэсний нахианы урын ялааны шинэ ур

6 сарын эхний арав хоногт Хэнтий аймгийн Биндэр, Батширээт, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумд, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, Эрдэнэ, Улаанбаатар хотын ногоон бүс, Горхи Тэрэлжийн БЦГ-ын ойн санд Сибирийн хүр эрвээхэйн **дунд, ахлах насны хүрэнцэр** хөрснөөс гарч, мод руу шилжилт хөдөлгөөн хийж тархалтын хүрээгээ тэлж байв.



Зураг 28-29. Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэрийн тооны нягтшил нэг модон дээр, хөрсний өнгөн хэсэгт

Мөн энэ хугацаанд Хэнтий аймгийн Дадал, Норовлин сумдын ойн санд Өрөөсгөл хүр эрвээхэй өндөгний шатнаас гарч, бага насны хүрэнцэрүүд шүлс татан, голомт үүсгэн, тархалт нь тэлж харин Баян-Адрага сумын Онон голын бургасанд ургамлын бөөсний (*Aphididae*) тархалт нэмэгдэж, хөнөөл учруулалт эхэлж байсан.

Хүснэгт 8. Хөнөөлт шавжийн төрөл, зүйл, тархалтын төлөв

Шавжийн төрөл зүйл		Тархалтын төлөв	
1	Lepidoptera	<i>Dendrolimus sibiricus</i>	+++
2		<i>Zeiraphera diniana</i>	++
3		<i>Erannis jacobsoni</i>	++
4		<i>Orgyia antiqua</i>	++
5		<i>Lymantria dispar</i>	++
6	Diptera	<i>Dasyneura laricis</i> ,	++

Тайлбар: + бага тархалттай, ++ дунд зэргийн тархалттай, +++ элбэг тархалттай

Сибирийн хүр эрвээхэйн олшролын үеийн үзүүлэлтүүд (хүрэнцэрийн биеийн хэмжээ)

Сибирийн хүр эрвээхэй нь (*Dendrolimus superans sibiricus* Tsetv.) Lepidoptera, *Lasiocampidae*) хойд Азийн шилмүүст ойг сүйтгэгч гол эрвээхэй юм. Зүүн-хойд Азиас (Baranchikov, Petko & Ponomarev, 2007; Mikkola & Stahls, 2008). Энэ зүйлийн географикийн тархалт нь ОХУ (Сибирь, Алс Дорнод), Казакстан, Хятад (хойд хэсэг), Монгол (хойд хэсэг) болон Солонгос зэрэг орнууд багтана (Rozhkov, 1963; CFIA, 2006).

Сибирийн хүр эрвээхэйн хөгжил 2 жилд буюу харьцангуй урт хугацаанд явагддаг, хүүхэлдэйлэхийн өмнөх жилд бойжлын ахлах үеийн хүрэнцэр ховдгоор хооллон модны шилмүүсийг үгүйртэл идэж физиологийн үйл явцад ноцтой сөрөг нөлөө үзүүлж сультан доройтуулахын зэрэгцээ хүрэнцэрийн биеийн үсэнд орших хорт шингэн нүдний хараа муутгах, сохлох зэргээр хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг.

а) Хүрэнцэрийн биеийн хэмжээ: Эрвээхэйн олшрол, нягтшилтаас хамааран биеийн хэмжээний үзүүлэлт харилцан адилгүй өөрчлөгддөг юм. Энэхүү ажлын гол зорилго нь хөнөөлт шавжийг тархалт, голомтыг илрүүлэх явдал байв. Бид Улаанбаатар хотын ногоон бүс Гачууртын Хуандай, Дээндий, Шар Хоолой, Улиастай, Өвөр Хадатын амны ойгоос Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэрийг мод доргиох болон гараар түүх аргаар дээж материал цуглуулав.

Нийт 1500 ш дээжийг санамсаргүй түүвэрлэх аргаар сонгон электрон штангенциркуль ашиглан биеийн урт, толгойн капсулын өргөнийг харьцуулан хэмжилт хийв. Хүрэнцэрийн хэмжилтийг харьцуулахад 2023 онд дундаж буюу 0.37 мм, харин 0.20 мм-0,48 мм бага, дунд, ахлах насны хүрэнцэрүүд тохиолдож ялгаатай($P=0.061$) гэсэн дүн гарч байна. 2023 онд судалгаанд хамрагдсан газар нутгаас сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэрийн бүх насных тохиолдож байгаа нь нягтшилт хэмжээ ихснийг харуулж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцрийн толгойн өргөний хэмжээ, 2023.04

Он	Дээжний тоо	Дундаж	Стандарт хазайлт	Стандарт алдаа	Доод утга	Дээд утга	F харьцаа	P-утга
2023	712	0.378	0.0034	0.0028	0.373	0.384	F=2.0	0.061



Зураг 30-33. Сибирийн хүр эрвээхэйн өндөг, хүрэнцэр, хүүхэлдэй, эрвээхэй



Зураг 34. Сибирийн хүр эрвээхэйн эвцэлдэгээ. 2023 оны 7-р сарын 19

Бид Богд хан уулын ойн сан, нийслэлийн ногоон бүс, Горхи Тэрэлжийн БЦГ тус бүр 10 нийт 30 ш феромонт урхийг 7 сарын 5-19-ны хооронд байрлуулж ажиглалт хийв.



Зураг 35-36. Феромонт урхи, байрлуулах явц

**Хүснэгт 10. Нийслэлийн ногоон бүсэд тархсан хөнөөлт хайрсан
далавчитны тооны нягтшилт**

Д\д	Газрын нэр	Судалгааны давтамж	Сибирийн хүр эрвээхэй	Якобсоны төөлүүрч эрвээхэй	Шинэсний шилмүүс хуйлагч
			хүрэнцэрийн нягтшилт 1 мод\бодгаль	хүрэнцэрийн нягтшилт 1 мод\бодгаль	хүрэнцэрийн нягтшилт 1 мод\бодгаль
1	Багануур дүүрэг	1	199-421	96-120	-
2	Дээндий	1	589-1300	220-267	79-96
3	Хуандай	2	480-1010	234-330	123-133
4	Шар хоолой	2	123-1300	121-168	56-78
5	Найман шарга	1	500-620	-	-
6	Улиастайн Баянголын ам	1	250-980	134-340	-
7	Чингэлтэй Зүрх уул	1	-	-	-
8	Толгойтын баруун салаа	1	-	-	-
9	Толгойтын зүүн салаа	1	-	-	-
10	Бурхантын ам	1	-	-	-
11	Гүнтийн ферм	1	-	-	-
12	Ар гүнт	1	-	-	-
13	Өвөр гүнт	1	-	-	-
14	Гүнтийн шархад	1	-	-	-
15	Нарийны ферм	1	-	-	-
16	Жаргалант тосгон	1	-	-	-
17	Цагаанчулуут	1	-	-	-
18	Бороож	1	-	-	-
19	Халзан	1	-	-	-
20	Мухар	1	-	-	-
21	Улиастайн баруун салаа	1	390-850	50-86	78-93
22	Улиастайн зүүн салаа	2	470-810	110-123	35-68
23	Гүнжийн хоолой	1	-	-	-
24	Бэлх	2	350-2500	68-176	-
25	Сэлх	2	390-800	34-111	-
26	Их, Бага баян	1	-	-	-
27	Шарга морьт	1	-	-	-
28	Санзай	1	-	-	-
29	Шадивлан	1	-	-	-
30	Яргайт	1	-	-	-
31	Яргайтын богино	2	-	89-90	-
32	Гоодойн ам	1	-	55-67	-
33	Жигжид	1	-	34-40	-
34	Майхан толгой	1	-	-	-
35	Баянбулаг	1	-	-	-
36	Баянзүрх 20-р хороо Нурамт	1	-	-	-
Дундаж			123-2500	34-340	35-133

хортны тооны нягтшилын тооцооноос харахад Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр голомт газраа нэг модон дээр 123-2500 бодгаль, Якобсоны төөлүүрч эрвээхэйн хүрэнцэр 34-340 бодгаль, Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэйн хүрэнцэр 35-133 бодгаль тохиолдов.


Судалгаа хийгдсэн газруудад тэмцлийн ажил явуулах талбайн сонголт

Судалгаанд нийслэлийн ногоон бүсийн 80.000.0мян.га ойн сангийн талбай хамрагдсанаас навч, шилмүүсний хөнөөлт шавжийн голомттой талбай **17190** га, тархалттай талбай **28246** га, хөнөөлийн голомт үүсэн тоо толгойн нягтшилтыг бууруулах тэмцлийн ажил зайлшгүй явуулах шаардлагатай **16200** га байгааг тогтоолоо(Зураг 44).

Хүснэгт 11. Нийслэлийн ногоон бүсийн ойн санд хөнөөлт шавжийн тархалт, голомттой талбайн хэмжээг тогтоосон дүн

	Газрын нэр Судалгаанд хамрагдсан талбай/га	Хортон тархсан талбай Хэмжээ, га Хэсэглэлийн дугаар	Голомттой талбай Хэмжээ, га Хэсэглэлийн дугаар	Хортны зүйлийн нэр, товчлол	
1	Багануур: Нарийны ам, Нүхэн зараа- 1100 га	Хэмжээ: 820 га	Хэмжээ: 530 га	DS, EJ, ZD	
2	Гачуурт тосгон: Гачууртын шар хоолой, Хуандай, Дээндий, Гүнжийн хоолой Нийт -14500,0 га	Хэмжээ: 10210 га 27,96,97,120,121,142,143,144,145,147,148,149,150,151,152,153,154,155,156,157,158,160,162,168,169,170,171,172,176,177,178,184,185,194,222,234	Хэмжээ: 6350 га 27,143, 144, 145,150,151, 152, 156, 157, 158, 160- 162, 169,170,172,176,184,185	DS, EJ, ZD	
3	Улиастай: Баруун салаа, Зүүн салаа, Улиастайн Баянголын ам, Нам даваа, Сүүл даваа, Хонхор, Шарын ам, Уртын даваа, Овооны энгэр, Цагаан эрэг, Зүрх уул, Гахайн чулуу. Нийт -15300,0 га	Хэмжээ: 11426 га 72, 73, 74, 76, 77, 71, 29, 30, 52, 53, 54, 55, 92-95, 118	Хэмжээ: 5913га 73,74,118,117, 119	DS, EJ, ZD	
4	Толгойт: Баруун, зүүн салаа Найрамдал: Баянголын ам Нийт -5000,0 га	- -	- -		
5	Гүнт: Ар гүнт, Өвөр гүнт, Нарийны ферм, Гүнтийн ферм, Гүнтийн шархад, Цагаанчулуут, Болоож, Халзан, Мухар. Нийт -16000,0 га	- -	- -	DS, EJ, ZD	
6	Зуслангийн бүс: Шадивлан, Яргайт, Яргайтын богино, Санзай Зуунмод, Гоодой, Жигжид, Майхан толгой, Хандгайт, Хандгайтын богино, Баянбулаг, Бэлх, Сэлх, Чингэлтэй Зүрх уул, Бурхантын ам, Их Бага, баян, Шарга морьт, Хуурай, Мухар, Нийт - 28100,0 га	Хэмжээ: 5790 га 89, 90,110, 112,113,114,115,116,138,140,141,118,119,120, 130,132,133,135	Хэмжээ: 4397 га 113,114, 115,116,118, 119,120	DS, EJ, ZD	
ДҮН		80.000.0	28 246	17 190	-

Товчилсон нэрний тайлбар: DS-Сибирийн хүр эрвээхэй, EJ-Якобсоны төөлүүрч эрвээхэй, ZD-Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй



Зураг 41. Ойн хөнөөлт шавжийн голомттой талбай

Хүснэгт 12. Нийслэлийн ногоон бүсэд 2023 онд хөнөөлт шавжтай тэмцэл явуулах талбайн хэмжээ, хэсэглэл, ялгарлын дугаар

Тэмцэл явуулах газрын нэр	Тэмцэл явуулах ойн хэсэглэлийн дугаар	Тэмцэл явуулах шаардлагатай талбайн хэмжээ/га	Хөнөөл учруулж байгаа шавжийн зүйл
1. Багануур: Нарийны ам, Нүхэн зараа 2. Гачуурт тосгон: Гачууртын шар хоолой, Хуандай, Дээндий, Гүнжийн хоолой 3. Улиастай: Улиастайн баруун салаа, Улиастайн зүүн салаа, Улиастайн Баянголын ам, Нам даваа, Сүүл даваа, Хонхор, Шарын ам, Уртын даваа, Овооны энгэр, Цагаан эрэг, Зүрх уул, Гахайн чулуу 4. Зуслангийн бүс: Сэлх Бэлх, Өвөх Хадат, Гоодой	27,143, 144, 145,150,151, 152, 156, 157, 158, 160- 162, 169,170,172,1 73175,176,18 4,185,73,74,1 18,117, 119, 89,90	16 200	-Сибирийн хүр эрвээхэй, -Якобсоны төөлүүрч эрвээхэй, -Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй
Тэмцэх арга	Авиамикробиологийн арга		

э

